



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 129

Улаанбаатар
хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих
төслийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.3, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны Н05/05 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд үйлдвэрийн ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих 550 айлын орон сууцны хотхоны бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгасугай.
2. Хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах бараа материал, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж 2019 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.
3. Хотхоны бүтээн байгуулалтын төслийг санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банкаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинэчлэн байгуулахыг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баярмагнай)-д тус тус үүрэг болгосугай.
4. Хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны эхний хагас жилд багтаан эхлүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт улирал тутам танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлэхийг Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт тус тус даалгасугай.



У.ХҮРЭЛСҮХ

Д.СУМЪЯАБАЗАР